

2014-05-09

Hepatit B

Өвчтөнд өгөх мэдээлэл ба өвчтөний баримтлах дүрэм. Халдвараас сэргийлэх эмч нараас өгөх халдвараас сэргийлэх тухай мэдээлэл.

Гепатит В гэж юу вэ?

Гепатит В бол элгийг үрэвсүүлдэг вирус бөгөөд ихэвчлэн цусаар болон бэлгээр халддаг. Гепатит В дэлхийн бүх өнцөг буланд байдаг бөгөөд зарим улсад илүү тархсан байдаг. Тус вирусын халдвар авсан насанд хүрэгчдийн талд нь ямар нэгэн өвчлөлийн шинж тэмдэг илэрдэггүй. Гепатит В халдвараар өвчилсөн хүнд дараах шинж тэмдэг илэрч болно: дотор муухай оргих, хоолны дуршил муудах, ядрах, гэдэс хэвлийгээр өвдөх, бие тэр чигээрээ өвдөж хөндүүрлэх, халуурах. Бие загатнаж болно, мөн нүдний цагаан, биеийн арьс шар өнгөтэй болж (шарлах) болно. Насанд хүрсэн хүн уг өвчлөлөөс хэдэн сарын дотор эмчлэгдэнэ, дараа нь бусдад халдваргүй болно. Харин хүүхэд тус халдварыг авбал удаан хугацааны (архаг) халдвартай болох нь элбэг. Архаг халдвартай болсон хүн бусдад халдвар тараах магадлалтай ба өөрийнх нь элэг ноцтой гэмтэл авах магадлалтай. Тиймд архаг халдвартай хүн эмчлэгч эмчтэйгээ тогтмол холбоотой байх хэрэгтэй, яагаад гэвэл тус хүнд эмчилгээ хийж, вирус элгийг гэмтээх магадлалыг багасгах шаардлагатай болж болох юм. Эдгээр эмчилгээ, эмчийн үзлэг үнэгүй. Гепатит В вирусын эсрэг вакцин байдаг бөгөөд халдвар аваагүй хүнд хийх, эсвэл халдвар авсан байх тохиолдолд тус тохиолдлоос хойш 48 цагийн дотор вакцин хийж болно.

Халдварлах зам

Гепатит В вирустай цус таны салст бүрхэвч эсвэл ил шарханд хүрвэл та халдвар авч болно. Гепатит В вирус бас бэлгээр халддаг, бэлгийн бүх төрлийн хавьтлаар халдах эрсдэл өндөр. Халдвар нэг гэрийн хүмүүс хоорондоо ойр харьцаатай байхад дамжих магадлалтай. Халдвартай эх хүүхэд төрүүлбэл төрүүлэх үедээ хүүхэддээ халдаах магадлалтай. Судасны тариагаар мансууруулах бодис хэрэглэгч өөр хүнтэй тариураа хуваалцвал халдварлах магадлал маш өндөр. Халдварыг тараахгүйн үүднээс вакцин хийвэл үр дүн сайн гардаг. Тиймд чиний гэр бүлийн хүмүүс болон ойр харьцаатай (бэлгээр хавьтдаг) хүн\хүмүүст үнэгүй вакцин хийж, тэдэнд вирус халдаахгүй байхыг эмнэлгээс санал болгоно.

Ямар үед Гепатит В вирус халдахгүй вэ?

Гепатит В вирус тэврэлт, хацрын үнсэлт эсвэл нулимсаар халдахгүй. Өтгөн, шээс, бөөлжис, нус цустай биш бол халдваргүй. Гэмтээгүй арьсанд цус хүрвэл бас халдахгүй.

Ажил мэргэжил эрхлэх үед

Гепатит В вирусын халдвар тус хүн ажил, сургуульд ихэнхдээ ямар нэгэн хязгаарлал үүсгэхгүй. Харин бусдад халдаах магадлал өндөр байж болох ажил, дадлага, үйл ажиллагаанд тэр хүнийг оролцохыг хязгаарлаж магадгүй юм.

Жирэмсэн ба төрөлт

Халдвартай эмэгтэй хүүхэд төрүүлбэл төрүүлэх үедээ хүүхэддээ халдаах магадлалтай. Тиймд бүх жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний хяналтад орох үед нь цусны шинжилгээ хийж, гепатит В вирусын халдвартай эсэхийг нь шалгадаг. Дөнгөж төрсөн хүүхдийг гепатит В вирусын халдвараас хамгаалахын тулд төрөнгүүт нь вакцин хийдэг.

Амаар, үтрээгээр, шулуун гэдсээр хавьтах үед бэлгэвч хэрэглэх

2014-05-09

Бэлгэвч хэрэглэх нь гепатит В вирус болон бусад бэлгийн халдвараас сэргийлэх сайн арга юм. Хэрвээ чиний ойр харьцаатай хүн тус вирусын эсрэг дархлаагүй бол (харин өмнө нь өвчилж байсан эсвэл вакцин хийлгүүлсэн хүнийг бол дархлаатай хүн гэнэ) түүнтэй хавьтах үед хавьталт эхлэхээс дуусах хүртэл бэлгэвч хэрэглэх ёстой. Эмэгтэй хүн углах бэлгэвч сайн хамгаалдаг байж болох боловч тус аргын үр дүнг одоогоор сайн судлаагүй байна. Бэлгэвчийн төрөл ямар байхаас шалтгаалахгүй бэлгэвчийг хавьталт эхлэхээс дуусах хүртэл нийт хугацаанд хэрэглэх ёстой.

Халдварыг мөрдөх

Халдвар авсан байж болох хүнийг олж, тэр хүнээр халдварыг цааш нь тараалгахгүй байх нь чухал. Тиймд халдварын мөрдөлт хийгддэг, чи хариуцсан мөрдөгчид нэгдүгээрт чамд халдаасан байж болох хүн\хүмүүсийн, хоёрдугаарт чи халдаасан байж болох хүн\хүмүүсийн нэр, тэдэнтэй холбогдох аргыг мэдэгдэх үүрэгтэй. Халдварын мөрдөлтөд чи хамтарч ажиллах үүрэгтэй. Ингэж холбогдсон хүмүүст чиний талаар мэдэгдэхгүй.

Бусдад халдвар өгөхгүйн тулд чи ямар ариун цэврийн зөвлөмж дагах вэ

- Бага ч гэсэн шархан дээр заавал наалт наа.
- Хэрвээ өөр хүн чиний шархыг боовол тэр хүнийг резинэн бээлий хэрэглэ гэж хэл.
- Цус болсон зүйлийг сайн боож хая.
- Цус болсон хувцсыг угаалгын машинаар угаа.
- Жишээ нь шалан дээр цус гоожвол арчаад, арчсан материалыг хая, дараа нь шалыг ус, цэвэрлэх бодисоор сайн угаа.

Бусдад халдвар өгөхгүйн тулд чи ямар дүрэм мөрдөх вэ

- Чиний эмчлэгч эмч чамайг эргэж ирэх шаардлагатай гэвэл чи заавал очих ёстой.
- Чи эмнэлэг, шүдний эмнэлэгт хандвал өөрийгээ халдвартайг мэдэгдэх ёстой.
- Чи цус гарах магадлалтай үед, жишээ нь шивээс хийлгэх, чих цоолуулах, биеийн бусад хэсэгт нүх гаргуулахад өөрийгээ халдвартайг мэдэгдэх ёстой.
- Гепатит В вирусын эсрэг вакцин хийлгүүлэх шаардлагатай байж болох хүний талаар (бэлгийн хамтран амьдрагч\гэр бүлийн хүн) эмчлэгч эмчид мэдэгдэх ёстой.
- Бэлгийн хавьталтад орохын өмнө нөгөө хүндээ өөрийгээ гепатит В вирусын халдвартай тухайгаа заавал мэдэгдэх үүрэгтэй. Энэ нь бүх төрлийн бэлгийн харьцаанд хамаатай. Чи бэлгэвч (аль ч төрлийн) хэрэглэх байсан ч өөрийгээ гепатит В вирусын халдвартай гэдгээ мэдэгдэх ёстой.
- Хэрвээ чиний бэлгийн харьцаатай хүн тус вирусын эсрэг дархлаагүй бол (харин өмнө нь өвчилж байсан эсвэл вакцин хийлгүүлсэн хүнийг дархлаатай хүн гэнэ) дараах хамаатай: үтрээ, шулуун гэдэс, аманд эр эрхтэн орсон байдлаар хавьтах нөхцөлд хавьталт эхлэхээс дуусах хүртэл бэлгэвч хэрэглэх ёстой.
- Хэрвээ чиний цус өөр хүний ил шарх, нүд, хамар, аманд орвол тэр дор нь усаар зайлуул. Мөн тэр хүнд өөрийн цусыг гепатит В вирусын халдвартай, тэр хүн аль болох хурдан хэсгийн эмнэлэг, халдвартын тасаг, 1177 (эрүүл мэндийн лавлах) руу хандаж, вакцин хийлгүүлэх шаардлагатай байж магадгүйг хэлэх ёстой.
- Чи сахлын хутга, шүдний сойз зэрэг ариун цэврийн зүйлээ өөр хүнтэй хуваалцаж болохгүй.
- Чи мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэдэг бол өөрийн тариуртай байж, хэрэглэсэн тариурыг өөр хүнээр хэрэглүүлэхгүй байх ёстой. Мансууруулах

2014-05-09

бодисын шингэн хольсон сав (эсвэл өөр хэрэгслийг) өөр хүнтэй хуваалцаж болохгүй. Эдгээр хэрэгслийг хадгалахдаа бусдад халдваргүй байлгана.

- Чи донорын журмаар цус, эр үрийн шингэн, эм өндөг, биеийн эрхтэн, биеийн эдийг хандивлаж болохгүй.

Гепатит В вирусын халдвар бол тус улсын халдвараас сэргийлэх хуулийн дагуу олон нийтэд аюултай гэж тооцогддог өвчин юм. Тиймд чи эмчийн заасан мөрдөх журмыг дагах үүрэгтэй. Хэрвээ та өөрт хамаатай мөрдөх журмыг өөрчлүүлэх хүсэлтэй бол аймгийн халдвараас сэргийлэх эмчид хандаж болно.